



МОНГОЛЫН ФИНТЕКИЙН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХУУЛИЙН НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

(Монголын Финтеийн Холбооны дэргэдэх
Мэдээллийн аюулгүй байдал,
Мэдээллийн технологийн мэргэжлийн зөвлөлөөс эмхтгэн боловсруулав)

Хувилбар: 1.0

Баталсан огноо: 2024 оны 05 сарын 31 өдөр

Батлав: М.Бямбасүрэн (Гүйцэтгэх захирал)

ТАЙЛБАР САНАМЖ

1. Энэхүү гарын авлага нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй финтек компаниудын Мэдээллийн аюулгүй байдлын зайлшгүй дагаж мөрдөх ёстой хуулийн заалтуудыг тусгасан бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх, хуульд хэрхэн нийцэж ажиллаж байгаа талаар компани дор бүрнээ үнэлэх боломжийг олгох зорилготой.
2. Гарын авлагыг Финтек салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь Мэдээллийн аюулгүй байдлын дотоод үйл ажиллагаандаа шууд хэрэгжүүлэх боломжтой.
3. Финтек салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд мэдээллийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор тэдгээртэй холбоотой хуулийн заалтуудыг багтаасан бөгөөд орхигдсон эсвэл шинэчлэгдсэн хуулийн заалтууд байх боломжтой.
4. Энэхүү гарын авлагыг Монголын финтекийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор Монголын финтекийн холбооны дэргэдэх Мэдээллийн аюулгүй байдал, Мэдээллийн технологийн мэргэжлийн зөвлөлөөс бэлтгэн боловсруулав.
5. Энэхүү гарын авлагад Финтек салбарт ажиллаж буй Мэдээллийн аюулгүй байдал, Мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, экспертүүд мөн тус салбарын хуулчид санал хүргүүлэв.
6. Энэхүү гарын авлагыг компани өөрийн дотоод үйл ажиллагаандаа нийцүүлж ашиглах боломжтой.

Монголын Финтекийн салбарын МАБ хуулийн нийцлийн үнэлгээний гарын авлага

		Нэр	Заалт	Хуулийн хэсэг, заалт	Шаардагдах материал	Нотлох баримт	Бүрэн нийцсэн	Хэсэгчлэн нийцсэн	Нийцээгүй	Оноо (1-5)
1	1	Автомат клиринг хаус системийн дүрэм	5.4.3	Нууцлалын токен хадгалалт, дамжуулалт, устгалт, түүний бүрэн бүтэн байдал, нууцлалыг хангах;						
2	2	Автомат клиринг хаус системийн дүрэм	13.2	ҮЦГТ болон оролцогч нь АСН систем рүү илгээсэн, хүлээн авсан болон Данены нэгдсэн сан дахь мэдээллийн үнэн зөв, нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, тус системээр дамжин хийгдэж байгаа гүйлгээ болон энэ дүрмийн 13.5-д зааснаас бусад мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй, дамжуулахгүй, нийгэд ил болгохгүй.						
3	3	Автомат клиринг хаус системийн дүрэм	13.3	ҮЦГТ болон оролцогч нь АСН систем рүү илгээсэн, хүлээн авсан гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгална.						
4	4	Автомат клиринг хаус системийн дүрэм	16.1	Төлбөр хүлээн авагчийн данснаас буцаалтын гүйлгээг зөвхөн тухайн хэрэглэгчийн зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.						
5	1	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	23.4	Байгууллага архивын орон тооны ажилтантай байх бөгөөд байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүрэг, архивт хадгалж байгаа баримтын тоо хэмжээг харгалзан энэ хуулийн 20.2-т заасан жишиг нормативыг үндэслэн байгууллагын архивын орон тоог тогтоож болно.						
6	2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	24.1.4.	Архивын баримтыг зориулалтын байр, тавиур, шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх;						
7	3	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	24.1.9	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих						
8	4	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	29.6.	Архивын баримтыг зориулалтын байранд холбогдох журам, стандартын дагуу тавиур, шүүгээнд хадгална.						
9	5	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	35.2	Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.						
10	6	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	46.3	Цахим баримт бичиг, мэдээллийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу файл, хавтас үүсгэн компьютерын хатуу дискт хадгална.						
11	7	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	46.4.	Цахим баримт бичиг түүний талаарх өгөгдлийг хадгалах нөөц хувийг бүрдүүлэх зорилгоор түүнийг тогтмол хугацаанд тусгай тээгч төхөөрөмж дээр хуулбарлан хадгална.						
18	1	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	2.1.4	Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх;	Шаардлагатай дотоод үйл ажиллагааны журам					
20	2	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	3.4	Зээлийн гэрээг эзэлдэгчтэй бичгээр эсхүл техникийн хэрэгсэл, программ хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан цахимаар байгуулж болно.						
12	3	Байгууллагын нууцын тухай хууль	4.2.4.3	Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно. Байгууллагын нууц нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхэд саад учруулахаар байж болохгүй.						
13	4	Байгууллагын нууцын тухай хууль	5.1	1.Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.						

14	5	Байгууллагын нууцын тухай хууль	6.1	Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй: 1/тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл; 2/тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл; 3/гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.						
15	6	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	4.4.1	ISO/IEC 27001 стандартыг хангах	ISO/IEC 27001 стандартыг хангах шаардлагатай баримт бичиг, журмууд	ISO/IEC 27001 гэрчилгээ авсан байх				
16	7	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	4.5	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны зардлаа бууруулах зорилгоор гуравдагч этгээдийн мэдээллийн технологийн системд холбогдон тухайн программ хангамжид боловруулагдсан мэдээллийг ашиглан зээл олгох тохиолдолд Хороонд заавал урьдчилан мэдэгдэнэ. Гуравдагч этгээд нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан шаардлагыг хангасан байна.						
17	8	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	4.6	Энэ журмын 4.1-д заасны дагуу финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7-д заасан үүргийг биелүүлж ажиллах ба холбогдох дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.						
19	9	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам	3.3.5	Харилцагчийн нууцлал, аюулгүй байдал;	Шаардлагатай дотоод үйл ажиллагааны журам					
21	1	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам	2.13.3	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэхэ нууцлал бүхий хяналтын системтэй байх.						
22	1	Зээлийн мэдээллийн тухай хууль	5.1.5	мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах						
23	2	Зээлийн мэдээллийн тухай хууль	17.1.5	Нийлүүлэх зээлийн мэдээллийн нууцлалыг хамгаалж чадах техник хэрэгсэл, компьютерийн программ хангамжийг ашигласан байх;						
24	3	Зээлийн мэдээллийн тухай хууль	20.2.4	Зээлдэгчийн нууцад хамаарах энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад мэдээллийг бусад задруулахгүй байх.	Шаардлагатай дотоод журам, заавар, гарын авлага, баримт бичиг боловруулах					
25	4	Зээлийн мэдээллийн тухай хууль	9.1.3	Зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэхэд мэдээлэл нийлүүлэгч, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн хооронд мэдээлэл өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох;	ЗМС компанитай хийсэн гэрээний дугаар	Гэрээ				
26	5	Зээлийн мэдээллийн тухай хууль	9.1.7	Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох үүрэг хүлээх.						
27	6	Зээлийн мэдээллийн тухай хууль	15.1.1.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд, түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь зээлийн мэдээллийн санд хуримтлагдсан мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад тараах, задруулах, ашиглах;						
28	1	Кибер аюулгүй байдлын тухай хууль	17.1.	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутамд, холбогдох журамд заасан нөхцөл, байдал үүссэн үед тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;						
29	2	Кибер аюулгүй байдлын тухай хууль	17.1.5	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх;						

30	3	Кибер аюулгүй байдлын тухай хууль	6.1	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ: 6.1.1.кибер аюулгүй байдлын бодлого, удирдлага, зохион байгуулалт; 6.1.2.кибер аюулгүй байдлыг хангах техник, технологийн арга хэмжээ; 6.1.3.кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ; 6.1.4.кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх арга хэмжээ.						
31	4	Кибер аюулгүй байдлын тухай хууль	7.2	Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журамд нийцсэн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай байна.						
32	5	Кибер аюулгүй байдлын тухай хууль	17.1.3	Мэдээллийн системийн үйлдлийн бүртгэлийг кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалах;						
33	7	Кибер аюулгүй байдлын тухай хууль	17.1.7	Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг жил тутамд, холбогдох журамд заасан нөхцөл, байдал үүссэн үед тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;						
34	1	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	13.1.	Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг энэ хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.						
35	1	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	12.8	Техникийн боломжоос хамааран гадаад цахим шилжүүлгийг дагалдаж байгаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаарх бүх мэдээллийг дотоодын холбогдох шилжүүлэгтэй хамтатгах боломжгүй нөхцөл үүсэж байвал мэдээлэх үүрэгтэй этгээд нь шилжүүлэгч байгууллагын болон бусад дамжуулагч байгууллагаас хүлээн авсан бүх мэдээллийг хамгийн багадаа 5 жил хадгална.						
36	2	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	15.1	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар заалтад нийцүүлэн мэдээлэх үүрэгтэй этгээд нь баримт материалыг дараах байдлаар хадгална:						
37	3	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	19.2	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн адгуу данс, гүйлгээг царцаах, сэжиглэхтэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагын ажилтнаас бусад аливаа хувь хүн, хуулийн этгээдэд задруулахыг хориглоно.						
38	4	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	8.1	Энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээ хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.						
39	5	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	8.2.	Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална						
73	1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	35.2.2	хуульд заасны дагуу олж авсан хязгаарлалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусад дамжуулахгүй, задруулахгүй байх;						
74	2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	35.2.5.	нийтийн мэдээллийн дэд бүтцэд ашигладаг нэвтрэх нэр, нууц үг, бусад хамгаалалтын хэрэгслийн нууцлал зэргийг алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, зөвшөөрөлгүй этгээд ашигласан, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн, эсхүл өөрийнх нь зөвшөөрөлгүй нэвтэрсэн тохиолдолд даруй нийтийн мэдээллийн систем хариуцагчид мэдэгдэх.						

40	1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	2.3.3.	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;						
41	2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	2.3.5.	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;						
42	3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулсан байх						
43	4	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	3.4.7.3	Хэрэглэгчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдэл, луйврын болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, гүйлгээг зогсоох, буцаах, түүнээс үүсэх маргааныг шийдвэрлэх боломжтой байна.						
44	5	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	3.5.3	Энэ журмын 3.5.2-г заасан этгээд нь банк, цахим мөнгө гаргагчтай нууцлалын өндөр түвшинд, бусад этгээд нэвтрэх боломжгүй сувгаар холбогдох техникийн бүтэц, зохион байгуулалттай байх;						
45	6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	7.13	Төлбөрийн үйлчилгээ үзүлэгч нь хэрэглэгч тухайн төлбөрийн хэрэгсэл, түүнтэй холбоотой нууц үг, гүйлгээ үүсгэхэд ашиглагдах бусад мэдээллийг гэж үрэгдүүлэх, бусад алдах тохиолдолд гарч болох эрсдэлийн талаар болон хууран мэхлэх, залилангийн шинжтэй гүйлгээнээс хэрхэн сэргийлэх талаар хэрэглэгчийг мэдээллээр хангана.						
46	7	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам	7.12.	Хэрэглэгчид олгох нууц үг, бусад нууцлах шаардлагатай мэдээллийг битүүмжилсэн байдлаар хүлээлгэн өгөх эсхүл хэрэглэгчээс бусад этгээд олж мэдэх боломжгүй байх нөхцөлийг хангасан байна.						

47	1	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;					
48	2	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;					
49	3	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	14.1.4	Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдал, системийн тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах;					
50	4	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	26.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүдэгч, оператор нь хэрэглэгчээс үйлчилгээний шимтгэл, хөлс авдаг бол энэ хуулийн 26.4-т заасны дагуу нийтэд мэдээнэ.					
51	5	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	26.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүдэгчийн энэ хуулийн 26.3-т заасан мэдээлэл нь Монголбанкнаас тавих шаардлагыг хангасан байна.					
52	6	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	26.8	Төлбөрийн үйлчилгээ үзүүдэгч нь хэрэглэгчийн дансны нууцлалыг хангах нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Монголбанкнаас баталсан журамд заасан хэлбэр, хугацаанд хэрэглэгчид мэдэгдэнэ					
53	7	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	30.1	Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүдэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүдэгчтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийг хүлээн авсан, эсхүл үүссэн өдрөөс хойш 15-аас доошгүй жил хадгална.					
54	1	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	20.1.5	Мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор үнэлгээг хийх.					
55	2	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	20.1.2	Мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг хуульд нийцүүлэн баталсан байх;					
56	3	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	7.1	Төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана: 7.1.1.энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан үндэслэлээр; 7.1.2.хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;					
57	4	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	14.1	Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд мэдээллийг гадаад улс дахь хүн, хуулийн этгээд болон олон улсын байгууллагад дамжуулан өгөхийг хориглоно.					
58	5	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	18.2.1	Хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх;	Шаардлагатай дотоод журам баталсан байх				
59	6	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	20.1.1	Энэ хуулийн 20.2-т заасан шаардлагад нийцүүлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдөх;					
60	7	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	20.1.3	Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгдэх мэдээллийн системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах бүхий л арга хэмжээг авсан байх;					
61	8	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	20.1.4	Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам, зааварчилгаа баталж, мөрдөх					
62	9	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	27.3.2	Ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах	Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.8-д заасан журмыг баталж, мөрдүүлэх.	Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан байх			
63	10	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	27.6	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийн талаарх анхааруулгыг иргэн саадгүй харах боломжтойгоор байршуулна.					

64	11	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	27.1	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байна						
65	12	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	29.1.	Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно.						
66	13	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	29.2	Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно.						
67	14	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	8.2	8.2.Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд дараах нөхцөлийг танилцуулж, зөвшөөрөл авна: 8.2.1.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго ойлгомжтой, тодорхой байх; 8.2.2.мэдээлэл хариуцагчийн нэр, хуулийн этгээд бол оноосон нэр, холбоо барих мэдээлэл; 8.2.3.цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт; 8.2.4.мэдээлэл боловсруулах, ашиглах хугацаа; 8.2.5.мэдээллийг нийтэд ил болгох эсэх; 8.2.6.мэдээллийг бусад дамжуулах эсэх, дамжуулахаар бол дамжуулах этгээд, дамжуулах мэдээллийн жагсаалт; 8.2.7.зөвшөөрлөө цуцлах хэлбэр.						
68	15	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	8.3	8.3.Мэдээллийн эзэн зөвшөөрлийг мэдээлэл хариуцагчид бичгээр өгөх бөгөөд энэ зөвшөөрөл нь цаасан, эсхүл цахим хэлбэртэй байна.						
69	16	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	18.2.7	18.2.7.мэдээллийг мэдээллийн эзний иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтын эх хувь, эсхүл цахимаар илгээсэн болон мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулгах;						
70	1	Цахим гарын үсгийн тухай хууль	18.4	18.4.Дэмжих систем нь үндсэн болон мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий бие даасан мэдээллийн систем байна. 18.5.Дэмжих системд дараах систем хамаарна: 18.5.1.танилт, нэвтрэлтийн систем; 18.5.2.нийтийн түлхүүрийн дэд бүтэц; 18.5.3.албан бичиг солилцооны дундын систем; 18.5.4.мэдээлэл солилцооны бүртгэлийн систем;						
71	2	Цахим гарын үсгийн тухай хууль	9.3.	Цагийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хараат бус, хөндлөнгийн байна.						
72	3	Цахим гарын үсгийн тухай хууль	9.4	Цагийн бүртгэлийн систем нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос тодорхойлсон сүлжээний цагийн сервертэй холбогдсон байна.						